



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/163/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Сугармаа

Утас: 70273465 Цахим хаяг: sugarmaag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахын урууцаг: tov@audit.gov.mn
Цахын хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/114
таныг _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцолсон хэсэг

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр нийт 326,804.6 мянган төгрөгийн гэрээ байгуулсан 2 төсөл арга хэмжээний дутуу санхүүжилт 241,732.7 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Хөрөнгө оруулалтын ажлуудын зарцуулалтын эрхийг 2025 оны 10 дугаар сараас хаасантай холбоотойгоор Жаргалант сумын ЗДТГ нь 304,462.5 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 28 зорилтын хүрээнд 95 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 81,7 хувьтай дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4126020279

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	110,550,585.7	333,827,871.4
33	АВЛАГА	63,472.2	241,732,730.0
335	Бусад авлага	63,472.2	241,732,730.0
3351	Байгууллагаас авах авлага	63,472.2	241,732,730.0
35	БАРАА МАТЕРИАЛ	110,487,113.5	92,095,141.4
351	Түүхий эд материал	6,393,889.0	5,663,281.4
35110	Тусгай зориулалттай материал	6,393,889.0	5,663,281.4
354	Хангамжийн материал	104,093,224.5	86,431,860.0
35410	Бичиг хэргийн материал	1,329,600.0	780,400.0
35420	Аж ахуйн материал	2,649,800.0	2,649,800.0
35430	Сэлбэг хэрэгсэл	36,460,000.0	18,035,000.0
35440	Түлш, шатах тослох материал	7,524,800.0	760,000.0
35450	Барилгын засварын материал	6,050,500.0	6,050,500.0
35470	Бусад хангамжийн материал	50,078,524.4	58,156,160.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,606,032,865.4	6,238,461,430.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,606,032,865.4	6,238,461,430.2
392	Биет хөрөнгө	5,116,248,465.4	5,749,131,030.2
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,883,447,301.3	2,920,717,851.3
39202	Хуримтлагдсан элэгдэл	-646,274,175.3	-767,650,382.2
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,936,850,346.6	2,331,179,737.7
39204	Хуримтлагдсан элэгдэл	-384,467,089.5	-413,020,462.1
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	445,188,098.2	510,618,411.9
39206	Хуримтлагдсан элэгдэл	-215,763,023.9	-203,145,879.0
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	171,465,833.0	170,318,548.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-63,429,029.8	-78,353,867.8
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,562,655,222.0	2,017,429,351.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-573,425,017.1	-738,962,278.6
393	Биет бус хөрөнгө	489,784,400.0	489,330,400.0
39301	Програм хангамж	4,220,000.0	4,220,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-750,000.0	-1,204,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	486,314,400.0	486,314,400.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,716,583,451.1	6,572,289,301.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,999,379.0	304,462,457.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,999,379.0	304,462,457.4
413	Өглөг	3,999,379.0	304,462,457.4
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	6,487,000.0
4136	Бусад өглөг	3,999,379.0	297,975,457.4
41361	Байгууллагад төлөх өглөг	3,999,379.0	297,975,457.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,712,584,072.1	6,267,826,844.3
51	Засгийн газрын хувь оролцоо	5,712,584,072.1	6,267,826,844.3
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	460,393,479.7	460,393,479.7
51101	Өмч: - төрийн	460,393,479.7	460,393,479.7
512	Хуримтлагдсан үр дүн	4,541,339,539.3	5,097,300,797.3
51210	Өмнөх үеийн үр дүн	4,541,339,539.3	4,546,057,404.1
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	551,243,393.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	710,851,053.1	710,132,567.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,716,583,451.1	6,572,289,301.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,808,362,310.4	2,255,140,047.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,044,691,247.9	704,823,477.1
120	Нийтлэг татварын бус орлого	2,044,691,247.9	704,823,477.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,044,691,247.9	704,823,477.1
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	2,006,018,135.9	693,348,477.1
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	38,673,112.0	11,475,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,763,671,062.5	1,550,316,570.8
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,414,430,600.0	1,130,958,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	349,240,462.5	419,358,570.8
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	79,234,212.0	94,896,780.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	265,699,750.5	321,517,290.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,306,500.0	2,944,500.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,618,741,885.4	1,701,233,654.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,618,741,885.4	1,632,930,070.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,315,187,590.4	1,591,047,714.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,752,249.9	798,101,870.5
210101	Үндсэн цалин	347,806,936.3	397,772,657.7
210102	Нэмэгдэл	251,109,349.9	300,406,560.4
210104	Урамшуулал	9,887,550.0	15,680,010.9
210105	Гэрээт ажлын хөлс	59,948,413.7	84,242,641.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,233,426.8	100,383,848.8
210201	Тэтгэврийн даатгал	57,514,600.9	68,427,922.9
210202	Тэтгэмжийн даатгал	6,852,822.9	7,991,761.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,386,295.4	3,996,023.5
210204	Ажилгүйдлийн даатгал	3,277,505.2	3,993,683.5
210205	Эрүүл мэндийн даатгал	13,202,202.5	15,974,457.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,416,014.6	116,129,662.1
210301	Гэрэл, цахилгаан	30,309,909.6	39,720,740.1
210302	Түлш, халаалт	65,106,105.0	76,408,922.0
2104	Хангамж, бараа материалын зардал	45,837,623.0	53,505,865.0
210401	Бичиг хэрэг	3,177,300.0	4,869,940.0
210402	Тээвэр, шатахуун	23,039,000.0	26,432,100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,100,000.0	2,320,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,521,323.0	12,264,352.9
210408	Бараа материал акталсны зардал	0.0	7,619,472.1
2105	Нормативт зардал	1,728,800.0	220,500.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,728,800.0	220,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,743,350.0	3,803,400.0
210604	Урсгал засвар	9,743,350.0	3,803,400.0
2107	Томилолт, зочны зардал	7,439,000.0	4,809,000.0
210702	Дотоод албан томилолт	7,439,000.0	4,809,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,725,351.0	8,726,495.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,956,564.0	0.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.0	1,936,800.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.0	0.0

210804	Тээврийн хэрэгслийн татвар	434,960.0	792,420.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.0	253,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	976,800.0	0.0
210807	Газрын төлбөр	1,195,027.0	5,744,275.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	380,311,775.1	505,367,073.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,177,506.0	44,229,300.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	354,134,269.1	461,137,773.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	303,554,295.0	41,882,356.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,423,679.5	34,928,143.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,027,300.0	34,928,143.2
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,754,979.5	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,641,400.0	0.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	286,130,615.5	6,074,048.4
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	286,130,615.5	6,074,048.4
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	880,164.5
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	880,164.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	68,303,584.0
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	68,303,584.0
223001	Бусад хөрөнгө	0.0	68,303,584.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,189,620,425.1	553,906,393.5
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	84,669,906.0	2,663,000.3
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.0	2,663,000.3

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,763,671,062.5	1,308,583,840.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,763,671,062.5	1,308,583,840.8
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,414,430,600.0	1,130,958,000.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,414,430,600.0	1,130,958,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	349,240,462.5	177,625,840.8
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	79,234,212.0	94,896,780.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	265,699,750.5	79,784,560.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,306,500.0	2,944,500.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,255,744,882.5	1,135,374,853.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,255,744,882.5	1,135,374,853.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	951,678,115.5	1,093,414,469.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,752,249.9	798,101,870.5
210101	Үндсэн цалин	347,806,936.3	397,772,657.7
210102	Нэмэгдэл	251,109,349.9	300,406,560.4
210104	Урамшуулал	9,887,550.0	15,680,010.9
210105	Гэрээт ажлын хөлс	59,948,413.7	84,242,641.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,233,426.8	100,383,848.8
210201	Тэтгэврийн даатгал	57,514,600.9	68,427,922.9
210202	Тэтгэмжийн даатгал	6,852,822.9	7,991,761.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,386,295.4	3,996,023.5
210204	Ажилгүйдлийн даатгал	3,277,505.2	3,993,683.5

210205	Эрүүл мэндийн даатгал	13,202,202.5	15,974,457.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,168,014.6	109,364,862.1
210301	Гэрэл, цахилгаан	30,309,909.6	39,720,740.1
210302	Түлш, халаалт	64,858,105.0	69,644,122.0
2104	Хангамж, бараа материалын зардал	45,988,223.2	38,648,792.9
210401	Бичиг хэрэг	3,327,900.0	3,859,840.0
210402	Тээвэр, шатахуун	23,039,000.0	19,667,450.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,521,323.2	12,801,502.9
2105	Нормативт зардал	1,992,300.0	519,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,992,300.0	519,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,998,250.0	4,863,300.0
210604	Урсгал засвар	9,998,250.0	4,863,300.0
2107	Томилолт, зочны зардал	7,439,000.0	4,809,000.0
210702	Дотоод албан томилолт	7,439,000.0	4,809,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,755,951.0	8,726,495.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,956,564.0	0.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.0	1,936,800.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.0	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	434,960.0	795,420.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	184,600.0	250,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	976,800.0	0.0
210807	Газрын төлбөр	1,195,027.0	5,744,275.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,350,700.0	27,997,300.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,350,700.0	27,997,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	304,066,767.0	41,960,383.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,936,151.5	35,006,171.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,539,772.0	35,006,171.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,754,979.5	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,641,400.0	0.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	286,130,615.5	0.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	286,130,615.5	0.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.0	6,074,048.4
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	6,074,048.4
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	880,164.5
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	880,164.5
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	507,926,180.0	173,208,987.7
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	507,926,180.0	173,208,987.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	507,926,180.0	173,208,987.7
2200	Дотоод эх үүсвэрээр	507,926,180.0	173,208,987.7
221001	Их засвар	4,200,000.0	0.0
222001	Тоног төхөөрөмж	398,000.0	0.0
223001	Бусад хөрөнгө	2,260,500.0	0.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	501,067,680.0	173,208,987.7
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-507,926,180.0	-173,208,987.7
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	460,393,479.67	710,851,053.08	4,541,339,539.30	5,712,584,072.05
D01	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	460,393,479.67	710,851,053.08	4,541,339,539.30	5,712,584,072.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	4,717,864.80	4,717,864.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	460,393,479.67	710,851,053.08	4,546,057,404.10	5,717,301,936.85
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-718,485.80	00.00	-718,485.80
D08	Тайлант үеийн үр дүн			551,243,393.21	551,243,393.21
D09	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	460,393,479.67	710,132,567.28	5,097,300,797.31	6,267,826,844.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,090,226,400.0	1,041,234,325.9	48,992,074.1	95.5
УРСГАЛ ЗАРДАЛ	1,090,226,400.0	1,041,234,325.9	48,992,074.1	95.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,054,668,400.0	1,006,228,154.9	48,440,245.1	95.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	716,470,600.0	714,470,094.9	2,000,505.1	99.7
Үндсэн цалин	436,022,000.0	397,772,657.7	38,249,342.3	91.2
Нэмэгдэл	176,310,800.0	217,632,284.8	-41,321,484.8	123.4
Урамшуулал	17,737,800.0	14,822,510.9	2,915,289.1	83.6
Гэрээт ажлын хөлс	86,400,000.0	84,242,641.5	2,157,358.5	97.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,989,500.0	89,989,500.0	0.0	100
Тэтгэврийн даатгал	61,330,600.0	61,330,600.0	0.0	100
Тэтгэмжийн даатгал	7,164,600.0	7,164,600.0	0.0	100
ҮОМШӨ-ний даатгал	3,582,400.0	3,582,400.0	0.0	100
Ажилгүйдлийн даатгал	3,582,400.0	3,582,400.0	0.0	100
Эрүүл мэндийн даатгал	14,329,500.0	14,329,500.0	0.0	100
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,382,700.0	109,364,862.1	17,837.9	100
Гэрэл, цахилгаан	39,721,600.0	39,720,740.1	859.9	100
Түлш, халаалт	69,661,100.0	69,644,122.0	16,978.0	100

Хангамж, бараа материалын зардал	47,951,200.0	33,489,102.9	14,462,097.1	69.8
Бичиг хэрэг	3,338,000.0	2,776,200.0	561,800.0	83.2
Тээвэр, шатахуун	23,713,200.0	15,711,400.0	8,001,800.0	66.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.0	2,200,000.0	200,000.0	91.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,500,000.0	12,801,502.9	5,698,497.1	69.2
Нормативт зардал	1,800,000.0	519,000.0	1,281,000.0	28.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.0	519,000.0	1,281,000.0	28.8
Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.0	4,863,300.0	136,700.0	97.3
Урсгал засвар	5,000,000.0	4,863,300.0	136,700.0	97.3
Томилолт, зочны зардал	8,500,000.0	4,809,000.0	3,691,000.0	56.6
Дотоод албан томилолт	8,500,000.0	4,809,000.0	3,691,000.0	56.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,623,500.0	8,726,495.0	13,897,005.0	38.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,873,500.0	1,936,800.0	1,936,700.0	50.0
Даатгалын үйлчилгээ	1,500,000.0	0.0	1,500,000.0	-
Тээврийн хэрэгслийн татвар	2,000,000.0	795,420.0	1,204,580.0	39.8
Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.0	250,000.0	0.0	100
Газрын төлбөр	15,000,000.0	5,744,275.0	9,255,725.0	38.3
Бараа үйлчилгээний бусад зардал	52,950,900.0	39,996,800.0	12,954,100.0	75.5
Бараа үйлчилгээний бусад зардал	52,950,900.0	39,996,800.0	12,954,100.0	75.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,558,000.0	35,006,171.0	551,829.0	98.4
Бусад урсгал шилжүүлэг	35,558,000.0	35,006,171.0	551,829.0	98.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,058,000.0	35,006,171.0	51,829.0	99.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.0	0.0	500,000.0	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	178,000,000.0	83,649,625.7	94,350,374.4	47.0
Дотоод эх үүсвэрээр	178,000,000.0	83,649,625.7	94,350,374.4	47.0
Их засвар	40,000,000.0	19,133,633.5	20,866,366.5	47.8
Бусад хөрөнгө	138,000,000.0	64,515,992.2	73,484,007.9	46.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,268,226,400.0	1,130,958,000.0	137,268,400.0	89.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,268,226,400.0	1,130,958,000.0	137,268,400.0	89.2
АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.0	35.0	0.0	100
Удирдах ажилтан	7.0	7.0	0.0	100
Гүйцэтгэх ажилтан	15.0	15.0	0.0	100
Үйлчлэх ажилтан	13.0	13.0	0.0	100
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	35.0	35.0	0.0	100
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.0	9.0	0.0	100
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.0	7.0	0.0	100
Гэрээт ажилтан	13.0	13.0	0.0	100
Улс төрийн албан хаагч (УТ)	6.0	6.0	0.0	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	349,240,462.50	100,185,814.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	104,252,264.50	100,185,814.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,279,274.32	100,185,814.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	69,547,325.88	83,631,775.55
210102	Нэмэгдэл	69,547,325.88	82,774,275.55
210104	Урамшуулал		857,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,646,984.44	10,394,348.76
210201	Тэтгэврийн даатгал	5,893,073.79	7,097,322.89
210202	Тэтгэмжийн даатгал	695,473.22	827,161.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	327,420.53	413,623.47
210204	Ажилгүйдлийн даатгал	342,140.18	411,283.47
210205	Эрүүл мэндийн даатгал	1,388,876.72	1,644,957.92
2104	Хангамж, бараа материалын зардал	5,141,500.00	5,159,690.00
210401	Бичиг хэрэг		1,083,640.00
210402	Тээвэр, шатахуун	5,141,500.00	3,956,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,936,900.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,936,900.00	1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	244,988,198.00	76,559,862.00
2200	Дотоод эх үүсвэрээр	169,000,000.00	76,559,862.00
223001	Бусад хөрөнгө	75,988,198.00	76,559,862.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	349,240,462.50	177,625,840.81
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	349,240,462.50	177,625,840.81
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	79,234,212.00	94,896,780.81
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	265,699,750.50	79,784,560.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,306,500.00	2,944,500.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1. Залруулсан алдаа

Аудитаар нийт 269,351.3 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг гүйцэтгэгч Голден мэт ХХК 11,961.5 мянган төгрөгийг өр төлбөрийн дансанд тусгалгүй орхигдуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-д "бүх өр төлбөр" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзад 146,002.2 мянган төгрөгийн акталсан үндсэн хөрөнгийг бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.7-д "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй 110,501.8 мянган төгрөгийн анхны үнэтэй 7 хөрөнгийн элэгдлийг тооцоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.6-д "бүх зардал" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4. Үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй 885.7 мянган төгрөгийн анхны үнэтэй 3 хөрөнгийн элэгдлийг илүү дүнгээр тооцсон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.6-д "бүх зардал" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.2. Залруулаагүй алдаа

Аудитаар нийт 57,267.3 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс 57,267.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс Сумын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цагдаагийн кубоны засварын ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр, наадмын талбайн байр зүйн зураг"-н ажил гүйцэтгэх гэрээг 10 дугаар сарын 14-ний өдөр тус тус гэрээ байгуулан, өр төлбөр үүсгэсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 58,963.6 мянган төгрөгөөр их боловч шинж чанарын хувьд материаллаг бус тул **"Өөрчлөлтгүй"** дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчин сумын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цагдаагийн кубоны засварын ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр, наадмын талбайн байр зүйн зураг"-н ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр байгуулан, нийт 57,267.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах", 13.1.2-т "Энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "...зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Шилэн дансанд байршуулбал зохих 3 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

Илрүүлэлт 2: Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 212 ширхэг үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн байна. Цаашид ашиглах боломжтой хөрөнгөд дахин үнэлгээ хийж үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", 31 дүгээр зүйлийн 31.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх зарчим", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-тай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох стандарт, журамд нийцүүлэн дахин үнэлгээ хийж, бүртгэлийг шинэчилж, зөрчлийг давтан гаргахгүй байхыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөөг, зөвлөмжийн хэрэгжилтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг гүйцэтгэгч Голден мэл ХХК 11,961.5 мянган төгрөгийг өр төлбөрийн дансанд тусгалгүй орхигдуулсан байна.	1	11,961.5	1	11,961.5			1	11,961.5		
Үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй 110,501.8 мянган төгрөгийн анхны үнэтэй 7 хөрөнгийн элэгдлийг тооцоогүй байна.	1	110,501.8			1	110,501.8	1	110,501.8		
Үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй 885.7 мянган төгрөгийн анхны үнэтэй 3 хөрөнгийн элэгдлийг илүү дүнгээр тооцсон байна.	1	885.7			1	885.7	1	885.7		
Акталсан үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзаар бүртгээгүй	1	146,002.2			1	146,002.2	1	146,002.2		
Дүн	4	269,351.3	1	11,961.5	3	257,389.7	4	269,351.3		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цагдаагийн кубоны засварын ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр, наадмын талбайн байр зүйн зураг"-н ажил гүйцэтгэх гэрээг 10 дугаар сарын 14-ний өдөр тус тус гэрээ байгуулан, өр төлбөр үүсгэсэн байна.	1	57,267.3			1	57,267.3						
Жаргалант сумын ЗДТГ-ын 2025 санхүүгийн тайланд аудит хийхэд 212 ш үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн байна. Гэвч цаашид ашиглах боломжтой хөрөнгө дахин үнэлгээ хийж үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	-					1	-				
Дүн	2	57,267.3			1	57,267.3	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Шилэн дансанд байршуулбал зохих 3 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй байна.	1	-					1	-			
Нийт дүн	1	-					1	-			

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn